



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЛТАЙ-УЛИАСТАЙ ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК-ИЙН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/102/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Ц.Хосжаргал  
Утас: 261628 Цахим хаяг: [khosjargalts@audit.gov.mn](mailto:khosjargalts@audit.gov.mn)  
Аудитор: Ж.Нямцэцэг  
Утас: 261628 Цахим хаяг: [nyamtsetsegj@audit.gov.mn](mailto:nyamtsetsegj@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Өлзийт экаунт аудит ХХК  
Захирал: Ц.Бямбажав  
Утас: 70130460 Цахим хаяг: [auditulziit@gmail.com](mailto:auditulziit@gmail.com)

Улаанбаатар хот  
2022 он

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	12
4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
4.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	12
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	12
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	13
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	15
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	15
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
8. Аудитын илрүүлэлт .....	16
8.1 Залруулсан алдаа .....	17
8.2 Төлбөрийн акт .....	17
8.3 Албан шаардлага .....	17
8.4 Зөвлөмж .....	18
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудиторын Олон Улсын Стандарт
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ЗГ	Засгийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НБББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТБОНӨТХ	Төрийн болон Орон Нутгийн Өмчийн Тухай Хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
УЦС	Усан Цахилгаан Станц
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦЭХ	Цахилгаан эрчим хүч
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭХЯ	Эрчим хүчний яам



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/586  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АЛТАЙ-УЛИАСТАЙ ЭРЧИМ  
ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК-ИЙН  
ЗАХИРАЛ Т.ГАНЗОРИГ ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Алтай-Улиастай Эрчим хүчний систем ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Алтай-Улиастай Эрчим хүчний систем ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Эрчим хүчний сайдын тушаалын 2021 оны 01 дүгээр сарын А/20 тоот тушаалаар 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 13,648.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 16,474.7 сая төгрөгөөр, алдагдлыг 2,825.9 сая төгрөг байхаар баталсан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 18 дугаар тушаалаар нийт орлогыг 1,244.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 648.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, алдагдлыг 596.2 сая төгрөгөөр бууруулж тодотгожээ.

Гүйцэтгэлээр 14,931.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 16,194.6 сая төгрөгийн зардал гарган, 1,263.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

## Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компани 2021 онд 2 зорилтын хүрээнд 3 арга хэмжээг төлөвлөснөөс, гүйцэтгэлийг 96 хувьтай гэж тайлагнасан байна.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



**2. Аудит хийсэн санхүүгийн тайлан****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	66,661,389.71	1,007,518,915.40
1.1.2	Дансны авлага	1,237,576,801.02	1,552,851,416.98
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	17,905,147.50	9,105,520.66
1.1.4	Бусад авлага	1,407,700.00	19,800,000.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	2,355,012,367.99	2,492,465,166.85
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	450,043,551.18	879,437,601.90
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>4,128,606,957.40</b>	<b>5,961,178,621.79</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	93,643,289,501.48	95,964,307,375.82
1.2.2	Биет бус хөрөнгө	5,067,855,399.83	5,065,377,512.35
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>98,711,144,901.31</b>	<b>101,029,684,888.17</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>102,839,751,858.71</b>	<b>106,990,863,509.96</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	1,012,992,617.51	29,375,783.54
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	617,791,487.86	826,246,950.28
2.1.1.4	НДШ - ийн өглөг	563,200.0	574,586.46
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	34,320,313.01	41,466,087.55
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	31,853,601.43	29,412,215.16

2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12	Бусад өглөг		
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,697,521,219.81</b>	<b>927,075,622.99</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	43,474,187,048.99	43,474,187,048.99
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>43,474,187,048.99</b>	<b>43,474,187,048.99</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>45,171,708,268.80</b>	<b>44,401,262,671.98</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	60,388,037,164.58	60,388,037,164.58
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,602,478,566.66	5,766,759,566.66
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	22,278,191,829.34	28,298,529,640.64
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(30,600,663,970.67)	(31,863,725,533.90)
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>57,668,043,589.91</b>	<b>62,589,600,837.98</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>102,839,751,858.71</b>	<b>106,990,863,509.96</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>10,012,673,034.99</b>	<b>12,333,130,011.31</b>
2	Борлуулалтын өртөг	13,530,188,848.50	15,455,221,390.57
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>(3,517,515,813.51)</b>	<b>(3,122,091,379.26)</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	3,067,969.21	608,873.95
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	3,421,370,451.33	4,951,824,514.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	81,986,723.52	95,758,803.11
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,773,254,721.62	2,709,116,716.67
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	348,077,626.59	238,665,405.76

13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	4,345,454.46	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг ( алдагдал)	(727,162,048.35)	(49,801,785.97)
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>(4,019,213,058.59)</b>	<b>(1,263,000,675.82)</b>
19	Орлогын татварын зардал	306,796.92	60,887.41
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(4,019,519,855.51)</b>	<b>(1,263,061,563.23)</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(4,019,519,855.51)</b>	<b>(1,263,061,563.23)</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	/төгрөгөөр/	
				Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>60,388,037,164.58</b>	<b>16,635,673,045.77</b>	<b>22,219,282,209.34</b>	<b>(26,471,450,539.37)</b>	<b>72,771,541,880.32</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(109,693,575.79)	(109,693,575.79)
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>60,388,037,164.58</b>	<b>16,635,673,045.77</b>	<b>22,219,282,209.34</b>	<b>(26,581,144,115.16)</b>	<b>72,661,848,304.53</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(4,019,519,855.51)	(4,019,519,855.51)
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт			58,909,620.00		58,909,620.00
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(11,033,194,479.11)			(11,033,194,479.11)
<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>60,388,037,164.58</b>	<b>5,602,478,566.66</b>	<b>22,278,191,829.34</b>	<b>(30,600,663,970.67)</b>	<b>57,668,043,589.91</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>60,388,037,164.58</b>	<b>5,602,478,566.66</b>	<b>22,278,191,829.34</b>	<b>(30,600,663,970.67)</b>	<b>57,668,043,589.91</b>



Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(1,263,061,563.23)	(1,263,061,563.23)
Зарласан ногдол ашиг					-
Өмчид гарсан өөрчлөлт			6,020,337,811.61		6,020,337,811.61
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		164,281,000.00			164,281,000.00
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>60,388,037,164.58</b>	<b>5,766,759,666.66</b>	<b>28,298,529,640.64</b>	<b>(31,863,725,533.90)</b>	<b>62,589,600,838.98</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>18,356,099,731.82</b>	<b>20,014,617,848.98</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	13,420,316,951.41	17,067,538,593.61
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	22,311,335.58	10,864,235.90
	Буцаан авсан албан татвар	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	2,869,733,300.00	2,394,975,809.08
	Бусад мөнгөн орлого	2,043,738,144.83	541,239,210.39
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>18,241,325,140.38</b>	<b>18,977,268,163.06</b>
	Ажиллагчдад төлсөн	4,164,534,352.98	4,011,924,013.09
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,284,541,060.45	1,238,325,901.09
	Бараа материал худалдан авахад төлсөн	5,684,503,681.42	8,356,317,938.52
	Ашиглалтын зардалд төлсөн	25,176,317.75	62,990,352.77
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,737,151,915.68	2,007,071,922.47
	Хүүний төлбөрт төлсөн	45,379.09	-
	Татварын байгууллагад төлсөн	1,166,326,411.24	1,164,819,631.39
	Даатгалын төлбөрт төлсөн	27,342,196.31	28,385,552.00
	Бусад мөнгөн зарлага	3,151,703,825.46	2,107,432,851.73
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>114,774,591.44</b>	<b>1,037,349,685.92</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>7,517,969.21</b>	<b>3,159.81</b>
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	4,450,000.00	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-

	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого	3,067,969.21	3,159.81
	Хүлээн авсан ногдол ашиг		
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>362,035,127.00</b>	<b>96,495,320.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	362,035,127.00	74,676,320.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	21,819,000.00
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(354,517,157.79)</b>	<b>(96,492,160.19)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
4	Валютын ханшийн зөрүү		
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(239,742,566.35)</b>	<b>940,857,525.73</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>306,403,956.06</b>	<b>66,661,389.71</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>66,661,389.71</b>	<b>1,007,518,915.44</b>

## 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>ЦЭХ-ний боловсруулалт</b>	<b>сая квт/ц</b>	<b>84.0</b>	<b>92.9</b>	<b>99.3</b>	<b>6.4</b>	<b>106.9</b>
	Худалдаж авсан ЦЭХ	сая квт/ц	53.2	69.1	73.2	4.1	105.9
	Үйлдвэрлэсэн цахилгааны эрчим хүч	сая квт/ц	30.7	23.7	26.1	2.3	109.9
2	Дотоод хэрэгцээний ЦЭХ	хувь	1.6	2.3	2.0	(0.3)	86.3
3	<b>Түгээлт ЦЭХ</b>	<b>сая квт/ц</b>	<b>83.5</b>	<b>92.3</b>	<b>98.8</b>	<b>6.5</b>	<b>107.0</b>
4	ЦЭХ-ний түгээлтийн алдагдал	хувь	20.0	18.9	18.5	(0.4)	98.1
5	<b>Нийт орлого</b>	<b>сая төг</b>	<b>13,463.1</b>	<b>14,893.0</b>	<b>14,931.5</b>	<b>38.5</b>	<b>100.3</b>
	Үүнээс: Борлуулалтын орлого	сая төг	10,012.7	12,276.5	12,333.1	56.6	100.5
	Үйл ажиллагааны бус орлого	сая төг	841.5	116.5	98.4	(18.2)	84.4
	Дизель түлшний санхүүжилт	сая төг	2,608.9	2,500.0	2,500.0	-	100.0
	Төсвийн санхүүжилт	сая төг				-	-
6	<b>Нийт зардал</b>	<b>сая төг</b>	<b>17,482.4</b>	<b>17,122.7</b>	<b>16,194.6</b>	<b>(928.2)</b>	<b>94.6</b>
	Үүнээс: Удирдлагын зардал	сая төг	398.2	433.2	405.9	(27.3)	93.7
7	<b>Үндсэн үйл ажиллагааны ашиг / алдагдал /</b>	<b>сая төг</b>	<b>(7,469.8)</b>	<b>(4,846.2)</b>	<b>(3,861.4)</b>	<b>984.8</b>	<b>79.7</b>
8	Татаасын орлого	сая төг	2,608.8	2,500.0	2,500.0	-	100.0
9	Цэвэр ашиг, / алдагдал/	сая төг	(4,019.4)	(2,229.7)	(1,263.1)	966.6	56.6
10	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	сая. квт/ц	1.3	1.2	1.1	(0.1)	93.9
11	Нийт ажиллагсдын тоо	тоо	338.0	339.0	339.0	-	100.0
12	Нийт авлага	сая төг	1,256.9	1,200.0	1,511.4	311.4	126.0
13	<b>Нийт өглөг</b>	<b>сая төг</b>	<b>1,663.0</b>	<b>1,100.0</b>	<b>852.8</b>	<b>(247.2)</b>	<b>77.5</b>
	Үүнээс: Богино хугацаат өглөг	сая төг	1,663.0	1,100.0	852.8	(247.2)	77.5
14	<b>Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ</b>	<b>сая төг</b>	<b>655.2</b>	<b>727.1</b>	<b>659.7</b>	<b>(67.4)</b>	<b>90.7</b>
15	Цалингийн сан	сая төг	4,182.1	4,628.01	4,630.93	2.9	100.1
16	Дундаж цалин	төг	1,031.09	1,137.66	1,138.38	0.4	100.1
	Борлуулж буй ЦЭХ-ний дундаж үнэ	төг	149.90	163.94	153.24	(10.7)	1.0
	Борлуулж буй ЦЭХ-ний өртөг	төг	261.74	228.66	201.21	(27.4)	2.0

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтай-Улиастай Эрчим хүчний систем ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг сайжруулах, бараа материал, түлш шатахууны тооцоотой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-аас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Өлзийт экаунт аудит ХХК-ийн аудитор Ч.Эрдэнэжав, туслах аудитор Б.Лхагвасүрэн, Б.Отгонномин-Эрдэнэ нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Ц.Бямбажав хэрэгжүүлсэн.

Алтай-Улиастай Эрчим хүчний систем ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 57 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. Тус байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулгад багтсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө зэрэг данснуудын нягтлан бодох бүртгэлийг хөтөлж мэдээлэл бэлтгэхдээ системийн хэмжээнд нэг дансны ангилал хэрэглээгүй нь зэрэгцүүлэгдэхүйц тууштай байж чадахгүй байна.

Алтай-Улиастай Эрчим хүчний систем ТӨХК-ийн дотоод хяналтын алба тайлант онд системийн хэмжээнд удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн, Техник хяналтын чиглэлээр дотоод аудитыг төлөвлөн хяналт тавьж зөвлөмж өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Алтай-Улиастай Эрчим хүчний систем ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын дүнгээр 17,461.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 261.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4. Санхүүгийн тайлангийн тодруулга**

---

### **4.1 Байгууллагын үйл ажиллагаа**

Алтай-Улиастай Эрчим хүчний систем ТӨХК нь Говь-Алтай, Завхан аймгийн нийт 21 мянга гаруй хэрэглэгчдийн ЦЭХ-ний өсөн нэмэгдэж буй хэрэглээг хосолмол эх үүсвэрээр тогтвортой найдвартай хангах зорилт тавин ажилладаг. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, хуваарилах үйл ажиллагаа, цахилгаан эрчим хүчээр зохицуулалттай хангах, цахилгаан эрчим хүчний шугамын болон тоног төхөөрөмжийн ашиглалт, угсралт, засвар, үйлчилгээ үзүүлэх гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компани гэсэн статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, үүнээс ТӨБЗГ 30.0 хувь, ЭХЯ 70.0 хувийг эзэмшиж байна.

### **4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин**

Алтай-Улиастай Эрчим хүчний систем ТӨХК нь Засгийн газрын 2008 оны 233 дугаар тогтоолыг үндэслэн байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй ...5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Эрчим хүчний төрийн өмчит хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох” заалттай нийцэж байна.

Алтай-Улиастай Эрчим хүчний систем ТӨХК нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нэг хүнд олгох сарын цалин, урамшууллыг 0.5 сая төгрөг буюу тайлант онд 69.1 сая төгрөгөөр төлөвлөж 59.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд Алтай-Улиастай эрчим хүчний систем ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тогтоолоор 2021 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөө баталж өртөг зардлыг хямдруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн өмчийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилтуудыг дэвшүүлж ажилласан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоолоор 339 орон тоогоор баталж, орон тоог бууруулан ажиллагаагүй, чиг үүргийг давхардал байхгүй.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;

### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Алтай-Улиастай Эрчим хүчний систем ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө	66,661.4	1,007,518.9	940,857.5
БХХО			
Авлага	1,256,889.6	1,581,756.9	324,867.3
Урьдчилгаа	450,043.6	879,437.6	429,394.1
Бараа материал	2,355,012.4	2,492,465.2	137,452.8
Үндсэн хөрөнгө	93,643,289.5	95,964,307.4	2,321,017.9
Биет бус хөрөнгө	5,067,855.4	5,065,377.5	(2,477.9)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>102,839,751.9</b>	<b>106,990,863.5</b>	<b>4,151,111.7</b>
Өр төлбөрийн дүн	45,171,708.3	44,401,262.7	(770,445.6)
Богино хугацаат өглөг	45,171,708.3	44,401,262.7	(770,445.6)
Урт хугацаат өглөг	43,474,187.0	43,474,187.0	-
Эздийн өмч	57,668,043.6	62,589,600.8	4,921,557.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>102,839,751.9</b>	<b>106,990,863.5</b>	<b>4,151,111.7</b>

Арилжааны банкин дахь мөнгөний үлдэгдэл 1,007.5 сая төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэл 1,527.2 сая төгрөг байна. Үүнээс бусад авлага 1,511.4 сая төгрөг, ААНОАТ-ын авлага 8.6 сая төгрөг, НӨАТ-ын авлага 7.1 сая төгрөгийг эзэлж байна.

Засгийн газрын 2020 оны 211 тоот тогтоолын дагуу айл өрх, зарим аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулаан эрчим хүчний төлбөрийг төрөөс хариуцахаар болсноор Засгийн газраас авах авлага 1,121.4 сая төгрөгөөр нэмэгдэж авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Тайлант онд барилгын ажлын төлбөрт 40.0 сая төгрөг, шугам, дэд станцын шинэчлэлд 40.5 сая төгрөг, засварын ажлын урьдчилгаанд 1.0 сая төгрөг, дизель түлшний урьдчилгаанд



423.4 сая төгрөг, бусад бараа үйлчилгээний урьдчилгаанд 32.9 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 2020 онд шилжүүлсэн 120.0 сая төгрөгийн ажил, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, 2019 онд шилжүүлсэн 187.0 сая төгрөг нь барилгын ажил дуусаагүй, гүйцэтгэлийг хүлээн аваагүй байна.

Урьдчилгаа данснаас тайлант онд ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж 89.9 сая төгрөгийг барилга байгууламжийн дансанд шилжүүлэн, 55.5 сая төгрөгийг бараа материал, зардлын дансанд хүлээн зөвшөөрсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,492.4 сая төгрөг болж 137.4 сая төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хил хаагдсан тул шаардлагатай сэлбэг хэрэгслийн нөөц бүрдүүлж аюулгүй ажиллагааг хангаснаас шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 7,970.1 сая төгрөгийн бараа материал худалдан авсан.

Оны эцэст 49.6 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь өвлийн их ачааллыг давахын тулд зайлшгүй шаардлагатай сэлбэг материалыг бэлтгэн бэлэн байдлыг хангах, сэлбэг хэрэгслийн нөөцийг бүрдүүлснээс болжээ.

Үндсэн хөрөнгө худалдан авсан 508.2 сая, хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэснээр 164.3 сая, дуусаагүй барилга 495.5 сая, тоног төхөөрөмжийг угсарч суурилуулсан 930.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, Алтай-Улиастай Эрчим хүчний систем ТӨХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 17 тогтоолоор охин компаниуд болох Богдын голын УЦС ХХК болон Завхан салбарт балансаас баланст шилжүүлсэн 107.3 сая, А-2/1391 тогтоолоор акталсан 1,419.2 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр хасагдсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 894.2 сая төгрөгийн өр төлбөр байна. Урт хугацаат өр төлбөр дансанд Тайширын усан цахилгаан станцыг барьж байгуулах хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор 2000 онд “Кувейтийн сан”-аас 22 жилийн хугацаатай авсан 21.1 сая ам.долларын, 2006 онд “Абу-Даби сан”-аас авсан 20 жилийн хугацаатай 13.0 сая ам.долларын зээл байна.

Улсын Их хурлын 2010 оны 72 дугаар тогтоолоор эдгээр зээлийн анх авсан үеийн ханшаа төгрөгт шилжүүлснээр 43,500.0 сая төгрөг болсон ба компанийн төлбөрийн чадвараас шалтгаалан зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт ажил гүйлгээний үр дүнд эдийн засгийн өгөөж буурсан, зардлын дүн эсвэл өртгийг найдвартай, үнэн зөв тооцох боломжтой нөхцөлд хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад 1,287.8 сая төгрөгөөр хасагдсан нь цахилгаан дулаан, ашиглалтын зардал 172.5 сая төгрөг, албан томилолт, хөдөлмөр хамгааллын зардал 238.3 сая төгрөгийг хэмнэсэн ба тайлант онд зарцуулж чадаагүй 877.0 сая төгрөгийн дизель түлшний зардлаас шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт гаднын үйлчилгээ, даатгалын зардал, газрын төлбөр, үл хөдлөх хөрөнгийн татвар, хөдөлмөр хамгааллын зардал, холбооны зардал, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, ашиглалтын зардал, үндсэн ба нэмэгдэл цалингийн зардал, шатах тослох материалын зардал, дизель түлшний зардал, ЭМД ба НДШ-ийн зардал, сэлбэг хэрэгслийн зардлуудыг хамруулсан байна. Үүнээс гаднын үйлчилгээ, даатгалын зардал, газрын төлбөр, үл хөдлөх хөрөнгийн татвар, хөдөлмөр хамгааллын зардал, холбооны зардлууд өртөгт хуваарилагдахгүй зардлуудыг өртөгт бүртгэж байна. НБББББ-д Алтай-Улиастай Эрчим хүчний систем ТӨХК, түүний салбар, охин компанийн зардлыг дараах байдлаар ангилан өртгийн төв, дэд төвүүдэд хуваарилан

бүртгэнэ гэснээс өөр нарийвчлан заагаагүй байгаа нь НББОУС 2-ын 12-т, “бараа материалын хувиргалтын зардал нь шууд хөдөлмөр гэх мэт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шууд хамааралтай зардлуудаас бүрддэг” гэсэн заалттай зөрчилдөж байна.

#### **4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Алтай-Улиастай Эрчим хүчний систем ТӨХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын тушаалын 2021 оны 01 дүгээр сарын А/20 тоот тушаалаар “Алтай-Улиастай эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 13,648.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 16,474.7 сая төгрөгөөр, 2,825.9 сая төгрөгийн алдагдал байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 709.5 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 09 дугаар сарын 06-ны өдрийн 18 тоот дугаар тушаалаар нийт орлогыг 14,893.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 17,122.7 сая төгрөгөөр, алдагдлыг 2,229.7 сая төгрөг байхаар тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 14,931.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 16,194.6 сая төгрөгийн зардал гарган, 1,263.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 14,931.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 38.5 сая төгрөг буюу 0.3 хувиар давсан нь цахилгаан эрчим хүчний хэрэглээ өссөн нь нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 16,194.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 928.1 сая төгрөг буюу 5.4 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь худалдаж авсан цахилгаан эрчим хүчний зардлыг хөнгөлсөн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 3 нэр төрлийн 40 ажилд өөрийн эх үүсвэрээс 573.7 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 1,263.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 966.6 сая төгрөгөөр бууруулсан нь зардлын дутуу зарцуулалт нөлөөлжээ.

### **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Алтай-Улиастай Эрчим хүчний систем ТӨХК-ийн нь тайлант онд нийт 6,369.6 сая төгрөгийн 847 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.



Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 1,297.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 1,224.5 сая төгрөгийг залруулж, 72.9 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5.7 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 144.6 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 18.2 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс акт 100.0 хувь, албан шаардлага 93.0 хувь, зөвлөмж 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	5.7	1	5.7	-	-	100.0
Албан шаардлага	4	144.6	4	135.1	-	-	93.0
Зөвлөмж	3	18.2	3	18.2	-	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>8</b>	<b>168.5</b>	<b>8</b>	<b>159.0</b>	-	-	<b>94.3</b>

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Алтай-Улиастай Эрчим хүчний систем ТӨХК-ийн 2002 онд ашиглалтад орсон 26.1 сая төгрөгийн дансны үнэ бүхий барилга байгууламж дансанд бүртгэлтэй, үл хөдлөх хөрөнгийн Y-0518000445 дугаар бүхий гэрчилгээтэй, Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд байрлах 3 өрөө орон сууцны өмчлөх эрх хувь хүний нэр дээр шилжсэн байгааг хуулийн хүрээнд шийдвэрлүүлсэн эсэхийг анхаарах.

Говь-Алтай аймгийн татварын хэлтэсийн 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн №НА-05210000028 тоот актаар граш, Гуулин тосгон дахь УЦС-ын барилга, бага далан, тунельтэй холбоотой 1,017.4 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн нөхөн татвар, торгууль, алданги төлүүлэхээр тогтоосныг үндэслэлгүй гэж үзэн холбогдох дээд байгууллагаар шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргасан. Үүний үр дүнд УИХ-ын 2022 оны хаврын чуулганаар Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулахаар хүлээгдэж байгаа бөгөөд энэхүү шийдвэрийг үндэслэн холбогдох дансны бичилтийг хийн санхүүгийн тайланд хэрхэн тусгасанг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 923.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 674.0 сая төгрөгийн алдааг залруулж, 1.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 246.8 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1.5 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн

Залруулагдаагүй 249.8 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 261.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

### 8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 674.0 сая төгрөгийн 5 алдааг залрууллаа. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл нь санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн үлдэгдлээс 35.5 сая төгрөгөөр илүү тоолж баталгаажуулсан, үндсэн хөрөнгийн тодруулга тайланд компани хооронд шилжсэн хөрөнгийг 44.5 сая төгрөгөөр дутуу тодруулсан;
- Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлангийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулгад 22.9 сая төгрөг бүртгэсэн, төрийн өмчийг тайлант онд 194.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалтыг 3.2 сая төгрөгөөр илүү тусгасныг авлага, 15.6 төгрөгөөр дутуу тусгасныг өр төлбөрийн дансанд бүртгээгүй;
- Цалин хөлсний тооцооноос ХАОАТ-ыг дутуу тооцоолон 2.8 сая төгрөгийн зөрүү үүсгэсэн, хувь хүний орлогын албан татварын өрийн үлдэгдэл 16.8 сая төгрөгийг 6.0 сая төгрөгөөр бууруулан алдаатай бүртгэсэн;
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулга тайлан нь ерөнхий журналын бараа материалын дүнгээс 335.1 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан залруулсан.

### 8.2 Төлбөрийн акт

Говь-Алтай аймаг дахь Цагдаагийн газрын ойд зориулж 1.5 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл бэлтгэж, зарцуулсан нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх," гэж заасныг НББОУС 1-ийн Үнэн зөв толилуулга ба СТОУС-ын нийцэлт 15-д Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

### 8.3 Албан шаардлага

Тайлант онд 698.0 сая төгрөгийн 43 удаагийн худалдан авах ажиллагаа зохион байгуулж бараа, ажил үйлчилгээ худалдан авсан ба үүнээс 220.6 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг худалдан авахдаа зориулалт, нэр төрлөөр нь багцлаагүй, босго үнийг баримтлаагүй нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.6-д "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хувааж тендер шалгаруулалт явуулж болно" гэж заасныг Засгийн газрын 2021 оны 124 дүгээр "Босго үнэ шинэчлэн батлах тухай" тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

Бараа, ажил үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэхдээ 26.2 сая төгрөгийн цахим и баримт бүрдүүлээгүй, татварын и-баримт цахим хуудсанд баримтын шивэлтэд хяналт хэрэгжүүлээгүй байгаа нь НӨАТ-ын тухай хуулийн 4.1.13-д "нэмэгдсэн өртгийн албан татварын падаан" гэж тухайн төлбөр тооцоо хийснийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар, албан татвар суутган төлөгчийн буюу худалдаа эрхлэгч, худалдан авагч албан татвар суутган төлөгчийн нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан

цаасан болон цахим баримт", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д " нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

#### **8.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. НБББББ-тай холбоотой асуудал**

###### **1.1 Илрүүлэлт**

Тус компанийн нягтлан бодох бүртгэлд ашиглаж буй 2016 онд боловсруулсан НБББББ-т борлуулсан бүтээгдэхүүний өртөгт орж байгаа зардлууд НББОУС 2-ын хувиргалтын зардлын шаардлагыг хангаагүй, системийн хэмжээнд хэрэглэж байгаа данснууд өөр өөр, элэгдэл тооцох жил ялгаатай байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." НББОУС 8-ын 5-д "Нягтлан бодох бүртгэлийн бодлого нь санхүүгийн тайланг бэлтгэж толилуулахдаа аж нэгжийн мөрддөг тусгай зарчим, суурь, дүрэм, журам, тогтсон практик", гэж заасантай мөн нэгтгэсэн тайлан нь зэрэгцүүлэгдэхүйц, тооцоолол нь тууштай байх зарчимтай, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хангахгүй, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

###### **1.2 Өгсөн зөвлөмж:**

НБББББ-ыг шинээр боловсруулж системийн хэмжээнд нэгдсэн зэрэгцүүлэгдэхүйц тооцооллын тууштай зарчмуудыг хэрэглэж, борлуулсан бүтээгдэхүүний өртөгт орж байгаа зардлуудыг, хэрэглэж байгаа данснууд, үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг нэгдсэн нэг бодлого арга зүйгээр хангаж, мөрдөх

##### **2. Бараа материалын түлш шатахууны тооцоотой холбоотой асуудал**

###### **2.1 Илрүүлэлт:**

Түлш шатахууны зарцуулалтыг норм нормативын дагуу зарцуулсан эсэхэд горим, сорил гүйцэтгэхэд 1.5 сая төгрөгийн шатахууны хэмнэлт, хэтрэлтийн тооцоог хийгээгүй, шууд бусад зардлын дансанд тусгасан нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 тоот тушаалын нэгдүгээр хавсралт "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм", НББОУС 1-ийн Үнэн зөв толилуулга ба СТОУС-ын нийцэлт 15-д "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

###### **2.2 Өгсөн зөвлөмж:**

Түлш шатахууныг бараа материалын дансанд орлогоор бүртгэж, зарцуулалтыг жолоочийн хуудсыг үндэслэн тооцоог бодож, хянаж зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1			Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл нь санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн үлдэгдлээс 38.4 сая төгрөгөөр илүү тоолж баталгаажуулсан, үндсэн хөрөнгийн тодруулга тайланд компани хооронд шилжсэн хөрөнгийг 44.5 сая төгрөгөөр дутуу.	Залруулсан	1	82,895.5	1	82,895.5								
2	"Алтай улиастай эрчим хүчний систем" ТӨХК	АХГ-2022/102/НА-СТА-ТӨА	Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлангийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулгад 22.9 сая төгрөг бүртгэсэн, төрийн өмчийг тайлант онд 194.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн	Залруулсан	1	217,502.2	1	217,502.2								
3			Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалтыг 18.9 сая төгрөгөөр дутуу тусгасанг өр төлбөр, авлагын дансанд бүртгээгүйг залруулсан.	Залруулсан	1	18,870.2	1	18,870.2								
4			Цалин хөлсний тооцооноос ХАОАТ-ыг дутуу тооцоолон 2.8 сая төгрөгийн зөрүү үүсгэсэн, хувь хүний орлогын албан татварын өрийн үлдэгдэл 16.8 сая төгрөгийг 6.0 сая төгрөгөөр бууруулан	Залруулсан	1	19,545.4	1	19,545.4								

		алдаатай бүртгэсэн залруулсан.														
		Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулга тайлан нь ерөнхий журналын бараа материалын дүнгээс 335.1 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан.	Залруулсан	1	334,976.3	1	334,976.3									
		Тус ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлдээ ашиглаж буй 2016 онд боловсруулсан НБББББ-д борлуулсан бүтээгдэхүүний өртөгт орж байгаа зардлууд НББОУС 2-ын хувиргалтын зардлын шаардлагыг хангаагүй, системийн хэмжээнд хэрэглэж байгаа данснууд өөр өөр, элэгдэл тооцох жил ялгаатай байгаад зөвлөмж хүргүүлэн ажиллахаар болсон.	НБББББ-ыг шинээр боловсруулж системийн хэмжээнд нэгдсэн зэрэгцүүлэгдэхүйц тооцооллын тууштай зарчмуудыг хэрэглэж борлуулсан бүтээгдэхүүний өртөгт орж байгаа зардлуудыг, хэрэглэж байгаа данснуудыг, үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг нэгдсэн нэг бодлого арга зүйгээр хангаж, мөрдөгдөж байгаа хууль дүрэм журамд нийцүүлэн шинэчлэх	1											1	
		Түлш шатахууны зарцуулалтыг норм нормативын дагуу зарцуулсан эсэхэд горим, сорил гүйцэтгэхэд 1.5 сая төгрөгийн шатахууны хэмнэлт хэтрэлтийн тооцоог хийгээгүй, бусад зардлын дансанд шууд тусгасан	Түлш шатахууныг зарцуулахдаа бараа материалын дансанд орлого авч жолоочийн тооцоог бодож хэмнэлт, хэтрэлтийг тооцож зарцуулалтыг хянаж байх	1	1,500.0										1	1,500.0
5		Говь-Алтай аймаг дахь Цагдаагийн газрын ойд зориулж 1.5 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл бэлтгэж, зарцуулсанд төлбөрийн акт тогтоох	Төрийн өмчийн зөв зохистой зарцуулж ажиллаагүйд төлбөрийн акт тогтоох.	1	1,459.0			1	1,459.0							
6		Бараа, ажил үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэхдээ 26.2 сая төгрөгийн цахим и баримт бүрдүүлээгүй,	Худалдан авалт хийхдээ цахим төлбөрийн баримтын системийн и баримтыг бүрдүүлэх	1	26,263.0					1	26,263.0					

			татварын и-баримт цахим хуудсанд баримтын шивэлтэд хяналт хэрэгжүүлээгүй байгаа												
<b>ДҮН</b>					<b>8</b>	<b>703,011.6</b>	<b>5</b>	<b>673,789.6</b>	<b>1</b>	<b>1,459.0</b>	<b>1</b>	<b>26,263.0</b>		<b>2</b>	<b>1,500.0</b>
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал															
7			Тайланд онд 220.6 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д” заалтыг, Засгийн газрын тогтоол Босго үнэ шинэчлэн батлах тухай тогтоолыг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.	Бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа зориулалт, нэр төрлөөр нь багцлах, босго үнийг харгалзан ХАА-ны аргыг зөв сонгох.	1	220,640.0					1	220,640.0			
8			Алтай-Улиастай Эрчим хүчний систем ТӨХК-ийн нь тайлант онд нийт 6,369.6 сая төгрөгийн 847 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.		1						1				
<b>ДҮН</b>					<b>2</b>	<b>220,640.0</b>					<b>2</b>	<b>220,640.0</b>			
<b>НИЙТ ДҮН</b>					<b>10</b>	<b>923,651.6</b>	<b>5</b>	<b>673,789.6</b>	<b>1</b>	<b>1,459.0</b>	<b>2</b>	<b>246,903.0</b>		<b>2</b>	<b>1,500.0</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15

№ 95/2021/50055

Улаанбаатар хот

АХГ 2022/102/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Алтай-Улиастай Эрчим хүчний систем ТӨХК-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Говь-Алтай аймаг дахь Цагдаагийн газрын ойн баярт зориулж 1,459,000.00 төгрөгийн бэлэг дурсгалын зүйл бэлтгэж, зарцуулсан байна.


Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх"; НББОУС 1-ын 15 Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь**

1. Ойн баяр, бэлэг дурсгалын зүйлд зориулан зарцуулсан 1,459,000.00 /Нэг сая дөрвөн зуун тавин есөн/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Алтай-Улиастай эрчим хүчний систем ТӨХК-ийн захирал Т.Ганзориг, А.Төгсбаяр нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ  
Ч.ЭРДЭНЭЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Утас 51-26-230

Ар хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,

10.10.10.20/Hichig\_Khereg/Akt/2022/0315 Auditin 2 Gazar 36.Docx

0001090240





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 437/А0150055  
АХГ-2022/102/НХ-СТН-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Алтай-Улиастай Эрчим хүчний систем ТӨХК-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 696,386,300 төгрөгийн 43 удаагийн худалдан авах ажиллагаа зохион байгуулж бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан. Үүнээс 220,639,995.40 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа зориулалт, нэр төрлөөр нь багцлаагүй, босго үнийг баримтлаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хувааж тендер шалгаруулалт явуулж болно", Засгийн газрын 2021 оны Босго шинэчлэх батлах тухай 124 дүгээр тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах, дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтай-Улиастай эрчим хүчний систем ТӨХК-ийн захирал Т.Ганзориг, А.Төгсбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ  
Ч.ЭРДЭНЭЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-122.Docx

0001081236





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 438/А0150055  
АХГ-2022/102/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Алтай-Улиастай Эрчим хүчний систем ТӨХК-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэхдээ 26,263,022.44 төгрөгийн цахим и баримт бүрдүүлээгүй, татварын и-баримт цахим хуудсанд баримтын шивэлтэд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу баримтын бүрдлийг хангаж, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтай-Улиастай эрчим хүчний систем ТӨХК-ийн захирал Т.Ганзориг, А.Төгсбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ  
Ч.ЭРДЭНЭЖАВ